**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ДУА-2025/77/НА-СТА-ТШЗ**

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох
Утас: 70592439
Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Оюун-Эрдэнэ
Утас: 70592225
Цахим хаяг: Oyun-erdenet@audit.gov.mn

Ахлах аудитор: Т.Батсайхан
Утас: 70593113
Цахим хаяг: Batsaikhant@audit.gov.mn

Аудитор: О.Баярсайхан
Утас: 70593208
Цахим хаяг: Bayarsaikhano@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

Дундговь аймаг

2025 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**


**1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ..... 2**

**2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ..... 4**

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 4

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..... 4

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 6

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 7

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 8

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 9

**3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ..... 9**

3.1 Төлбөрийн акт ..... 10

3.2 Албан шаардлага ..... 10

3.3 Зөвлөмж ..... 10

**4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ..... 16**


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

# 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2025.02.25 № 25

танай ______ -ны № ______ -т

ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА
Э.ЧАГНААДОРЖ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Дундговь аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын болон санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад Монгол улсын Засгийн газрын шийдвэрээр 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс төрийн албан хаагчийн үндсэн цалинг нэмсэнтэй холбоотой цалингийн зардал өмнөх оноос 274.7 сая төгрөгөөр өссөн байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

**Аудитын гол асуудал**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал байхгүй. Харин тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ нь санхүүгийн үр дүнгийн тайланд гэрэл, цахилгааны болон түлш, халаалтын зардлыг бараа үйлчилгээний бусад зардлаар тайлагнасан. Уг алдааг аудитын явцад залруулсан тул жилийн эцсийн санхүүгийн тайлангийн дүгнэлтэд нөлөөлөөгүй.

**Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлж, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 90.6 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Р.МӨНХТОГТОХ

# 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 84,284,705.03 | 109,738,265.03 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 7,085,529.00 | 24,185,529.00 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 7,085,529.00 | 24,185,529.00 |
| 3121 | Төгрөг | 7,085,529.00 | 24,185,529.00 |
| 31214 | Бусад төсөл, нөөцийн харилцах | 7,085,529.00 | 24,185,529.00 |
| 33 | АВЛАГА | 57,825,397.16 | 59,858,307.16 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 57,825,397.16 | 59,858,307.16 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 19,373,778.87 | 25,694,428.87 |
| 354 | Хангамжийн материал | 19,373,778.87 | 25,694,428.87 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 299,200.00 | 245,750.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 9,474,394.87 | 15,904,894.87 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 2,845,000.00 | 3,049,900.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 6,755,184.00 | 6,493,884.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 370,529,514.79 | 796,505,508.95 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 370,529,514.79 | 796,505,508.95 |
| 392 | Биет хөрөнгө | 293,923,125.75 | 720,027,453.19 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 170,343,678.02 | 344,342,758.02 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (4,126,021.44) | (8,252,042.88) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 137,696,500.00 | 376,176,500.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (116,000,633.04) | (135,007,916.66) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 333,759,939.04 | 369,037,741.04 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (246,588,822.77) | (275,731,521.46) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 43,160,984.91 | 82,328,984.91 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (24,322,498.97) | (32,867,049.78) |
| 393 | Биет бус хөрөнгө | 76,606,389.04 | 76,478,055.76 |
| 39301 | Програм хангамж | 1,650,000.00 | 1,650,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,243,610.96) | (1,371,944.24) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 76,200,000.00 | 76,200,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 454,814,219.82 | 906,243,773.98 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 454,814,219.82 | 906,243,773.98 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 454,814,219.82 | 906,243,773.98 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 162,529,981.94 | 162,529,981.94 |
| 51101 | Өмч: - төрийн | 162,529,981.94 | 162,529,981.94 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 292,152,591.10 | 743,582,145.26 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 292,152,591.10 | 292,152,591.10 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 451,429,554.16 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 131,646.78 | 131,646.78 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 454,814,219.82 | 906,243,773.98 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 1,167,763,769.80 | 1,818,371,929.91 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 354,780,894.80 | 601,371,225.16 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 354,780,894.80 | 601,371,225.16 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 161,688,790.84 | 121,151,343.16 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 151,803,261.84 | 101,151,343.16 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 9,885,529.00 | 20,000,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 812,982,875.00 | 1,217,000,704.75 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 789,755,700.00 | 1,155,784,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 789,755,700.00 | 1,155,784,000.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 3,800,000.00 | 58,502,687.50 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3,800,000.00 | 58,502,687.50 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 16,988,175.00 | - |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 16,988,175.00 | - |
| 1330 | Төсвийн захирагчдаас | 2,439,000.00 | 2,714,017.25 |
| 133003 | Хөрөнгийн | 2,439,000.00 | 2,714,017.25 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 951,638,414.23 | 1,366,942,375.75 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 951,638,414.23 | 1,366,942,375.75 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 860,532,144.58 | 1,216,937,444.07 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 619,555,092.00 | 894,238,053.00 |
| 210101 | Үндсэн цалин | 362,188,634.00 | 474,426,450.00 |
| 210102 | Нэмэгдэл | 155,781,332.00 | 280,947,903.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 28,520,000.00 | 63,968,000.00 |
| 210104 | Урамшуулал | 73,065,126.00 | 74,895,700.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 77,614,797.00 | 109,279,745.26 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 52,800,490.98 | 74,310,216.05 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,211,822.63 | 8,742,380.51 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,960,659.10 | 4,371,190.42 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,240,163.53 | 4,371,190.42 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,401,660.76 | 17,484,767.86 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 3,712,500.00 | 68,969,349.92 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | - | 6,899,129.92 |
| 210302 | Түлш, халаалт | - | 57,480,220.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | - | 4,590,000.00 |
| 210304 | Байрны түрээс | 3,712,500.00 | - |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 3,343,820.90 | 2,863,200.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,613,300.00 | 1,832,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 264,000.00 | - |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 457,270.90 | 391,050.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,009,250.00 | 639,850.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 389,000.00 | 175,900.00 |
| 210604 | Урсгал засвар | 389,000.00 | 175,900.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 2,161,300.00 | 2,120,200.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,161,300.00 | 2,120,200.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 9,869,115.63 | 9,687,141.60 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 9,273,048.43 | 9,106,300.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 344,800.00 | 338,200.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 229,267.20 | 242,641.60 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22,000.00 | - |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 143,886,519.05 | 129,603,854.29 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 95,708,734.50 | 68,654,966.45 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 48,177,784.55 | 60,948,887.84 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 91,106,269.65 | 150,004,931.68 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 16,021,200.00 | 99,655,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 2,800,000.00 | 2,500,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 9,421,200.00 | - |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 94,355,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,800,000.00 | 2,800,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 75,085,069.65 | 50,349,931.68 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 74,999,682.97 | 48,529,684.52 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 216,125,355.57 | 451,429,554.16 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 216,125,355.57 | 451,429,554.16 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 914,407,268.68 | 1,333,405,120.66 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 103,863,393.68 | 119,118,433.16 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 103,863,393.68 | 119,118,433.16 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 103,863,393.68 | 119,118,433.16 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 93,977,864.68 | 99,118,433.16 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 9,885,529.00 | 20,000,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 810,543,875.00 | 1,214,286,687.50 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 789,755,700.00 | 1,155,784,000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 789,755,700.00 | 1,155,784,000.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 3,800,000.00 | 58,502,687.50 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3,800,000.00 | 58,502,687.50 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 16,988,175.00 | - |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 16,988,175.00 | - |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 901,454,339.68 | 1,309,600,120.66 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 901,454,339.68 | 1,309,600,120.66 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 810,348,070.03 | 1,159,595,188.98 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 619,555,092.00 | 894,238,053.00 |
| 210101 | Үндсэн цалин | 362,188,634.00 | 474,426,450.00 |
| 210102 | Нэмэгдэл | 155,781,332.00 | 280,947,903.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 28,520,000.00 | 63,968,000.00 |
| 210104 | Урамшуулал | 73,065,126.00 | 74,895,700.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 77,614,797.00 | 109,279,745.26 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 52,800,490.98 | 74,310,216.05 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,211,822.63 | 8,742,380.51 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,960,659.10 | 4,371,190.42 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,240,163.53 | 4,371,190.42 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,401,660.76 | 17,484,767.86 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 3,712,500.00 | 46,193,501.74 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | - | 4,123,501.74 |
| 210302 | Түлш, халаалт | - | 37,480,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | - | 4,590,000.00 |
| 210304 | Байрны түрээс | 3,712,500.00 | - |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 6,221,187.40 | 5,932,550.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,823,500.00 | 1,778,850.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,109,000.00 | 3,049,900.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 414,937.40 | 378,950.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 873,750.00 | 724,850.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 389,000.00 | 175,900.00 |
| 210604 | Урсгал засвар | 389,000.00 | 175,900.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 2,161,300.00 | 2,120,200.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210702 | Дотоод албан томилолт | 2,161,300.00 | 2,120,200.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 9,869,115.63 | 9,687,141.60 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 9,273,048.43 | 9,106,300.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 344,800.00 | 338,200.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 229,267.20 | 242,641.60 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22,000.00 | - |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 90,825,078.00 | 91,968,097.38 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 90,825,078.00 | 91,968,097.38 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 91,106,269.65 | 150,004,931.68 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 16,021,200.00 | 99,655,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 2,800,000.00 | 2,500,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 9,421,200.00 | - |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 94,355,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,800,000.00 | 2,800,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 75,085,069.65 | 50,349,931.68 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 74,999,682.97 | 48,529,684.52 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 12,952,929.00 | 23,805,000.00 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 5,867,400.00 | 6,705,000.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 5,867,400.00 | 6,705,000.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 5,867,400.00 | 6,705,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 5,867,400.00 | 6,705,000.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | (5,867,400.00) | (6,705,000.00) |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 7,085,529.00 | 17,100,000.00 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 7,085,529.00 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 7,085,529.00 | 24,185,529.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|
| 2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 162,529,981.94 | 1,443,872.57 | 74,715,009.74 | 238,688,864.25 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 1,312,225.79 | 1,312,225.79 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 162,529,981.94 | 1,443,872.57 | 76,027,235.53 | 240,001,090.04 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 216,125,355.57 | 216,125,355.57 |
| 2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 162,529,981.94 | 131,646.78 | 292,152,591.10 | 454,814,219.82 |
| 2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 162,529,981.94 | 131,646.78 | 292,152,591.10 | 454,814,219.82 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 162,529,981.94 | 131,646.78 | 292,152,591.10 | 454,814,219.82 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 451,429,554.16 | 451,429,554.16 |
| 2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 162,529,981.94 | 131,646.78 | 743,582,145.26 | 906,243,773.98 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|
| I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | **1,285,784,000.00** | **1,204,552,501.48** | **81,231,498.52** |
| УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | **1,188,648,100.00** | **1,107,697,501.48** | **80,950,598.52** |
| Бараа, үйлчилгээний зардал | **1,188,648,100.00** | **1,107,697,501.48** | **80,950,598.52** |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | **878,249,600.00** | **844,724,553.00** | **33,525,047.00** |
| Үндсэн цалин | 421,132,700.00 | 474,426,450.00 | (53,293,750.00) |
| Нэмэгдэл | 398,688,800.00 | 231,434,403.00 | 167,254,397.00 |
| Унаа, болон бусад нөхөн олговор | 24,215,000.00 | 63,968,000.00 | (39,753,000.00) |
| Урамшуулал | 34,213,100.00 | 74,895,700.00 | (40,682,600.00) |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | **116,126,700.00** | **103,090,557.76** | **13,036,142.24** |
| Тэтгэврийн даатгал | 77,366,100.00 | 70,101,568.55 | 7,264,531.45 |
| Тэтгэмжийн даатгал | 9,690,100.00 | 8,247,245.51 | 1,442,854.49 |
| ҮОМШӨ ний даатгал | 4,845,100.00 | 4,123,622.92 | 721,477.08 |
| Ажилгүйдлийн даатгал | 4,845,100.00 | 4,123,622.92 | 721,477.08 |
| Эрүүл мэндийн даатгал | 19,380,300.00 | 16,494,497.86 | 2,885,802.14 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | **46,280,000.00** | **46,193,501.74** | **86,498.26** |
| Гэрэл цахилгаан | 4,210,000.00 | 4,123,501.74 | 86,498.26 |
| Түлш, халаалт | 37,480,000.00 | 37,480,000.00 | - |
| Цэвэр, бохир ус | 4,590,000.00 | 4,590,000.00 | - |
| Хангамж, бараа материалын зардал | **6,166,600.00** | **5,932,550.00** | **234,050.00** |
| Бичиг хэрэг | 1,789,100.00 | 1,778,850.00 | 10,250.00 |
| Тээвэр (шатахуун) | 3,049,900.00 | 3,049,900.00 | - |
| Шуудан  холбоо, интернэтийн төлбөр | 408,500.00 | 378,950.00 | 29,550.00 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс | 919,100.00 | 724,850.00 | 194,250.00 |
| Нормативт зардал | **132,300.00** | **-** | **132,300.00** |
| Нормын хувцас зөөлөн эдлэл | 132,300.00 | - | 132,300.00 |
| Эд хогшил худалдан авах | **384,700.00** | **175,900.00** | **208,800.00** |
| Урсгал засвар | 384,700.00 | 175,900.00 | 208,800.00 |
| Томилолт, зочны зардал | **2,120,200.00** | **2,120,200.00** | **-** |
| Дотоод албан томилолт | 2,120,200.00 | 2,120,200.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | **9,758,300.00** | **9,687,141.60** | **71,158.40** |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 9,151,600.00 | 9,106,300.00 | 45,300.00 |
| Даатгалын үйлчилгээ | 338,200.00 | 338,200.00 | - |
| Тээврийн хэрэгслийн татвар | 243,100.00 | 242,641.60 | 458.40 |
| Тээврийн хэрэгслийн оношилгоо | 25,400.00 | - | 25,400.00 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | **129,429,700.00** | **95,773,097.38** | **33,656,602.62** |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 129,429,700.00 | 95,773,097.38 | 33,656,602.62 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | **97,135,600.00** | **96,855,000.00** | **280,600.00** |
| Бусад урсгал шилжүүлэг | 97,135,600.00 | 96,855,000.00 | 280,600.00 |
| Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 2,780,600.00 | 2,500,000.00 | 280,600.00 |
| Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж | 94,355,000.00 | 94,355,000.00 | - |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | **1,285,784,000.00** | **1,204,552,501.48** | **81,231,498.52** |
| УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | **1,155,784,000.00** | **1,107,254,315.48** | **48,529,684.52** |
| Улсын төсвөөс санхүүжих | 1,155,784,000.00 | 1,107,254,315.48 | 48,529,684.52 |
| ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | **130,000,000.00** | **97,298,186.00** | **32,701,814.00** |
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 130,000,000.00 | 97,298,186.00 | 32,701,814.00 |
| АЖИЛЛАГСДЫН ТОО | 35.00 | 29.00 | 6.00 |
| Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - |
| Гүйцэтгэх ажилтан | 31.00 | 26.00 | 5.00 |
| Үйлчлэх ажилтан | 3.00 | 2.00 | 1.00 |

### 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| ҮЗҮҮЛЭЛТ | ГҮЙЦЭТГЭЛ | ЗӨРҮҮ |
|---|---|---|
| I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | **55,702,687.50** | **(55,702,687.50)** |
| УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | **55,702,687.50** | **(55,702,687.50)** |
| Бараа, үйлчилгээний зардал | 55,702,687.50 | (55,702,687.50) |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 49,513,500.00 | (49,513,500.00) |
| Нэмэгдэл | 49,513,500.00 | (49,513,500.00) |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 6,189,187.50 | (6,189,187.50) |
| Тэтгэврийн даатгал | 4,208,647.50 | (4,208,647.50) |
| Тэтгэмжийн даатгал | 495,135.00 | (495,135.00) |
| ҮОМШӨ ний даатгал | 247,567.50 | (247,567.50) |
| Ажилгүйдлийн даатгал | 247,567.50 | (247,567.50) |
| Эрүүл мэндийн даатгал | 990,270.00 | (990,270.00) |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | **2,800,000.00** | **(2,800,000.00)** |
| Бусад урсгал шилжүүлэг | 2,800,000.00 | (2,800,000.00) |
| Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 2,800,000.00 | (2,800,000.00) |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | **58,502,687.50** | **(58,502,687.50)** |
| Нэмэлт санхүүжилтийн орлого | 58,502,687.50 | (58,502,687.50) |
| Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 58,502,687.50 | (58,502,687.50) |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 31,934.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 28,345.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,471.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж, 2.056.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 62.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн актыг хүргүүллээ.

***Залруулагдаагүй алдаа:***

Аудитаар нийт 3,589.0 мянган төгрөгийн зөрчил[1] илэрч, зөвлөмж, албан шаардлага, төлбөрийн акт хүргүүллээ. Албан хаагчид дотоод албан томилолт нөхөн олговор **62.0** мянган төгрөгийг илүү тооцож олгосон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т /*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар*

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

*төлөвлөж, зарцуулах*/, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтооолоор батлагдсан “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 2.4-т /*Албан томилолтоор ажилласан хоногийн тоог албан томилолтоор ажиллуулах шийдвэрт тэмдэглэсэн хуанлийн хоногоор тооцож гаргана. Албан томилолтоор явсан, буцаж ирсэн өдрийг нэгтгэн нэг хоногт тооцно.*/ гэж заасныг;

**3.1 Төлбөрийн акт**

1. Албан хаагчид дотоод албан томилолт нөхөн олговор **62.0** мянган төгрөгийг илүү тооцож олгосон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т /*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*/, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтооолоор батлагдсан “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 2.4-т /*Албан томилолтоор ажилласан хоногийн тоог албан томилолтоор ажиллуулах шийдвэрт тэмдэглэсэн хуанлийн хоногоор тооцож гаргана. Албан томилолтоор явсан, буцаж ирсэн өдрийг нэгтгэн нэг хоногт тооцно.*/ гэж заасныг;

**3.2 Албан шаардлага**

1. Хоолны хөнгөлөлтийн зардлаас **2,056.0** мянган төгрөгийг дотоод албан томилолтын нөхөн олговорт олгож эдийн засгийн ангиллыг баримтлаагүй. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д /*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*/, 16 дугаар зүйлийн 16.5.2-т /*батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*/, 16.5.5-д /*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*/ гэж заасныг;
2. Жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг чанаргүй зохион байгуулсан, тооллогын явцад хяналт тавиагүй, тооллогын дүн санхүүгийн тайлангийн дүнгээс зөрүүтэй. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-т /*Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана*/, 73.2 /*Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана*/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т /*Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах*/, 20.2.6-т /*Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах*/ гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг холбогдох хууль тогтоомжийн дагуу эдийн засгийн ангиллыг баримтлан хяналттай, үр ашигтай зарцуулах, актын төлбөрийг барагдуулж төсвийг хохиролгүй болгох, цаашид зөрчлийг дахин давтан гаргахгүй байх.

**3.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

- Төсвийн зардал, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой

  *Илрүүлэлт:*

  1. Нягтлан бодогчийн ажлыг хагас, бүтэн жилээр дүгнэн үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон болович санхүүгийн тайлангийн аудитаар "Өөрчлөлтгүй" дүгнэгдсэн үндэслэлээр урамшууллыг давхардуулан олгожээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх /*Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*/, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4 дэх /*улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох*/, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх /*Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно*/ 15.1.3 дахь /*Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох*/, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2 дахь “/*Төрийн албан хаагчид улирлын ажлын үр*

*дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна*/ заалтыг;

2. Шилэн дансны цахим хуудсанд санхүүжилтийн орлого, зарлага, төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийг бүрэн байршуулаагүй. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4.1.3 дахь /*тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх*/ заалтыг мөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж*:

Төсвийг хэмнэлттэй зарцуулж, мөнгөн урамшууллыг давхардуулан олгохгүй байх, холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллах;

Шилэн дансны тухай хууль, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга нийтлэг стандарт тогтоосон журмыг унших судлан хэрэгжилтэд хяналт тавих, мэдээлэл байршуулах ажил хариуцсан ажилтны ажлын хариуцлагыг сайжруулах;

*Зөвлөмжийн хэрэгжилт:*

Зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5[2]-д заасан хугацаанд, зөвлөмжийн хэрэгжилтийг 2025 оны 05 сарын 15-ны дотор ирүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

[2] Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Мөнгөн гүйлгээний тайланд хөрөнгийн зардлыг зөрүүтэй тайлагнасан. | 1 | 5,570.0 | | | 1 | 5,570.0 | 1 | 5,570.0 | | | | |
| Санхүүгийн үр дүнгийн тайланд гэрэл, цахилгааны болон түлш, халаалтын зардлыг бараа үйлчилгээний бусад зардлаар тайлагнасан. | 1 | 22,775.8 | | | 1 | 22,775.8 | 1 | 22,775.8 | | | | |
| Дүн | **2** | **28,345.8** | | | 2 | **28,345.8** | **2** | **28,345.8** | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Нягтлан бодогчийн ажлыг дүгнэн үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон боловч санхүүгийн тайлангийн аудитаар "Өөрчлөлтгүй" дүгнэгдсэн үндэслэлээр урамшууллыг давхардуулан олгосон. | 1 | 1,471.0 | | | | | 1 | 1,471.0 | | |
| Жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг чанаргүй зохион байгуулсан, тооллогын явцад хяналт тавиагүй. | 1 | - | | | 1 | - | | | | |
| Хоолны хөнгөлөлтийн зардлаас дотоод албан томилолтын нөхөн олговор олгож эдийн засгийн ангиллыг баримтлаагүй. | 1 | 2,056.0 | | | 1 | 2,056.0 | | | | |
| Дотоод албан томилолтын нөхөн олговрыг илүү тооцож олгосон. | 1 | 62.0 | | | 1 | 62.0 | | | | |
| | | | | | | | | | | |
| **Дүн** | **4** | **3,589.0** | **-** | **-** | **3** | **2,118.0** | **1** | **1,471.0** | **-** | **-** |

**Нийцлийн аудитын зөрчлийн нэгтгэл :** /мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны цахим хуудсанд санхүүжилтийн орлого, зарлага, төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийг бүрэн байршуулаагүй. | 1 | - | | | | - | 1 | - | | |
| | | | | | | | | | | |
| **Дүн** | **1** | **-** | **-** | **-** | | **-** | **1** | **-** | **-** | **-** |